

БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ

2024 он

НЭГ. МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН БОДЛОГЫН ОНЦЛОГ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

Ирэх 2025 онд төрийн оролцоог багасгаж, хувийн хэвшлийг дэмжсэн дараах төсвийн бодлогыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

1. Хөгжлийн хөрөнгө оруулалт, томоохон бүтээн байгуулалтыг санхүүжүүлнэ.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого болон “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, 2025 онд төсвийн хөрөнгө оруулалтыг бүсийн авто зам, эрчим хүч, дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн хөгжлийн бүтээн байгуулалтуудыг санхүүжүүлэхэд чиглүүлж, мөн бусад салбарт өмнөх онуудад эхлүүлсэн төслүүдийг дуусгаж, шинэ хөрөнгө оруулалтыг түр хойшлуулах үндсэн зарчим, бодлогыг баримталсан.

2.Бүсчилсэн хөгжлийн бодлоготой нийцүүлэн хувийн хэвшлийг дэмжих татварын бодлогыг хэрэгжүүлнэ.

Бүсчилсэн хөгжлийн бүтээн байгуулалтын ажлыг зөвхөн улсын төсвийн эх үүсвэрээр хийх боломжгүй тул татварын дэмжлэг үзүүлж хувийн хэвшлийг урамшуулан идэвхжүүлэх бодлого баримтлах нь зүйтэй байна. Иймд бүсийн тэргүүлэх чиглэлд нийцсэн томоохон төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт хийхийг уриалан дэмжсэн татварын цогц бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

3.Хүний хөгжлийг дэмжсэн, хүний эрхийг дээдэлсэн бодлого

Ирэх 2025 онд цалин, тэтгэмжийг инфляцтай уялдуулан нэмэгдүүлэх зорилт тавьж байна. Энэ хүрээнд төрийн албан хаагчийн цалин, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр болон нийгмийн халамжийн тэтгэврийг 2025 оны 1 дүгээр сарын 1-ээс 6.0 хувиар нэмэгдүүлэхээр тооцож шаардлагатай зардлыг төсвийн төсөлд тусгасан.

4.Орон сууцжуулалтыг үндэсний баялгийн сангаар дамжуулан хэрэгжүүлнэ.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, хот хөдөөгийн сэргэлт, төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд Үндэсний орон сууцны корпорацыг байгуулж “Миний анхны байр”, “Миний амины орон сууц”, “Миний сонголт орон нутаг”, “Миний сонголт төрийн алба”, болон “Миний түрээсийн орон сууц” гэсэн иргэдийг орон сууцжуулах таван багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Төсвийн орлого, татвар

Төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр:

Ирэх 2025 онд төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, бааз суурийг тэлэх, төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- Хөгжлийн төслүүдийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг дэмжиж, төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- Экспортыг дэмжих, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Татварын бодлогын чиглэлээр:

Бүсийн тэргүүлэх чиглэлд нийцсэн томоохон төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт хийхийг уриалан дэмжсэн татварын цогц бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөлөө. Тухайлбал хувийн хэвшлээс бүсчилсэн хөгжлийн зорилтод нийцсэн томоохон хөрөнгө оруулалт хийхэд төслийн бүтээн байгуулалтын шатанд хамгийн өндөр ачаалал болдог импортын гаалийн албан татварыг чөлөөлж, НӨАТ төлөх хугацааг 4 жилээр хойшлуулна. Мөн үйл ажиллагаа эхлэх үеэс төлж эхэлдэг үл хөдлөх хөрөнгийг татварыг 0 хувь хүртэл бууруулах боломжийг бүрдүүлж, орлого олж эхэлсэн эхний 5 жилд төлсөн орлогын татварын 90 хувийг буцаан олгон 1 хувийн татвартай болгох зэргээр татварын цогц дэмжлэг үзүүлнэ.

Ирэх оноос эхлэн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан бүсүүдийг төрөлжүүлэн хөгжүүлэх татварын ялгаатай бодлого хэрэгжүүлж эхэлнэ. Энэ хүрээнд нийт 23 төрлийн татварыг бүсээр ялгаатай тогтоох боломж бүрдэж, бүс орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалт татах, өрсөлдөх боломжтой болно.

Шинэ сэргэлтийн бодлогын аж үйлдвэржилтийн сэргэлтийн зорилтын хүрээнд ирэх оноос Монгол Улс салбар харгалзахгүйгээр бүх төрлийн боловсруулах үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалтын тоног төхөөрөмжийн импортын гаалийн татварыг 100 хувь хөнгөлж, нэмүү өртөг шингээн үйлдвэрлэл эрхэлдэг бүх аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.

Төсвийн урсгал зардал

- **Төрийн албан хаагчийн цалин, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулж нэмэгдүүлнэ.** Ирэх 2025 онд Иргэдийн орлогыг хамгаалах арга хэмжээг үргэлжлүүлж 226.2 мянган төрийн албан хаагчдын цалин хөлсийг инфляцтай уялдуулан 6.0 хувиар нэмэгдүүлэхэд шаардагдах зардлыг тусгасан. Мөн 2023 онд нийгмийн даатгалын багц хууль, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тогтооход баримтлах итгэлцүүрийг шинэчлэн баталсан. Хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 510.0 мянган иргэний тэтгэврийг инфляцтай уялдуулан 6.0 хувиар нэмэгдүүлэх, итгэлцүүр шинэчлэхтэй холбоотой нэмэлтээр шаардагдах зардлыг тус тус тооцож тусгасан.

- **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх нийгмийн халамжийг сайжруулна.** Байнгын асаргаа шаардлагатай хүүхэдтэй өрхийн орлогын баталгааг сайжруулах үүднээс тэдэнд олгодог амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 2025 онд 6.0 хувиар нэмэгдүүлэхийн зэрэгцээ хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэмжийг уг нэмэгдсэн хэмжээнээс 30 хувиар өсгөх, мөн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн живхний зардлыг нийгмийн халамжаас олгохоор тус тус тооцсон.
- Боловсролын хүртээмжийг үр ашигтай байдлаар нэмэгдүүлнэ.
 - Улсын хэмжээнд шинээр ашиглалтад орох 50 ерөнхий боловсролын сургуулийн нийтлэг үйлчилгээг хувийн хэвшлээр гүйцэтгүүлнэ.
 - Хувийн хэвшлийн эзэмшиж байгаа шаардлага хангасан байрыг боловсролын сургалтын үйл ажиллагааны зориулалтаар түрээслэнэ.
 - Цэцэрлэг, сургууль, дотуур байрны хоолны зардлыг нэмэгдүүлнэ.
- Эрчим хүчний үнэ тарифын шинэчлэлийг үргэлжлүүлнэ.
- Хүний эрхийг хангах, хамгаалах байдлыг сайжруулна.
- Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт шинжлэх ухаан, үйлдвэрлэл, хүний нөөцийн цогц бодлого хэрэгжүүлнэ.
- Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

Төсвийн хөрөнгө оруулалт

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого болон “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, 2025 онд төсвийн хөрөнгө оруулалтыг бүсийн авто зам, эрчим хүч, дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн хөгжлийн бүтээн байгуулалтуудыг санхүүжүүлэхэд чиглүүлж, мөн бусад салбарт өмнөх онуудад эхлүүлсэн төслүүдийг дуусгаж, шинэ хөрөнгө оруулалтыг түр хойшлуулах үндсэн зарчим, бодлогыг баримталлаа.

Улсын хэмжээнд төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 633.3 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 33 төсөл, арга хэмжээ хэрэгжих ба үүний 99.7 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 8 төсөл нь өмнөх онуудаас шилжин хэрэгжинэ. Цаашид Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, нийгмийн суурь үйлчилгээг 20 минутын дотор хүргэх шинэ орчин нөхцөлийг бүрдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах арга хэмжээг бодитой хэрэгжүүлэх мега төслүүд болох “Хөшигийн хөндийн туннел”, “Өөдөө тэмүүлэх Монгол” ган татлагат гүүрэн байгууламж төслүүдийн санхүүжилтийг үе шаттайгаар шийдвэрлэж, хэрэгжүүлнэ.

ХОЁР. БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

Төсвийн орлогын төлөвлөлт

Төсвийн орлогын 2025 оны төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчилж, өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн орчны хүрээнд Сангийн яамнаас ирүүлсэн чиглэл, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, сүүлийн 6 жилийн судалгаа зэрэгт үндэслэн 63.3 тэрбум төгрөг байхаар тооцлоо.

Хувь хүний орлогын албан татвар

- Цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогын албан татвараар 2024 онд 11.7 тэрбум төгрөг төлөвлөсөн ба 80.0 хувийг төр төсвийн байгууллагад ажиллагсдын цалин хөлсний орлого болон түүнтэй адилтгах орлогын албан татвараас бүрдэж байгаа бөгөөд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 100 хувь биелэхээр байна. Төрийн албаны тухай хуулийн өөрчлөлт, цалингийн тогтолцооны шинэчлэлт, Сангийн яамнаас тооцсон суурь орлогын хүрээнд 2025 онд цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогыг хянасан суурь орлогыг 31.6 хувиар өсгөж 15.4 тэрбум төгрөгөөр тооцлоо.
- ХААН банк, Төрийн банк, Хас банк банкин дахь хадгаламж эзэмшигч иргэдийн судалгаа, Сангийн яамнаас тооцсон суурь тооцооллыг үндэслэн хадгаламжийн хүүгийн орлогын албан татварыг 2.9 тэрбум төгрөг төлөвлөж, сумдад хуваариллаа.
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу тус орлогыг 180.6 сая төгрөгөөр төлөвлөлөө.
- Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтоор 2024 онд 700 иргэнд 817.1 сая төгрөгийг олгосон. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн өөрчлөлтөөр 2021 оноос татварын буцаан олголтоор 6.0 сая хүртэл төгрөгийг авах боломжтой болсонтой холбогдуулан 2025 онд 950 сая төгрөг олгохоор тооцлоо.

Хүснэгт № 01. 2021-2025 оны хувь хүний орлогын албан татварын

буцаан олголтын судалгаа (сая.төг)

№	Үзүүлэлт	2021 гүйц	2022 гүйц	2023 гүйц	2024 гүйцэтгэл	2025 төлөвлөгөө
1	Хүний тоо	804	816	756	1250	1250
2	Олгосон дүн (сая.төг)	416.6	471.2	611.8	817.1	950.0

Хөрөнгийн албан татвар

Хөрөнгийн албан татварын орлогод үл хөдлөх хөрөнгийн албан татвар, бууны албан татвар, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын

орлогыг хамааруулж, нийт 4,889.2 сая төгрөгөөр төлөвлөв. Бүтцийн хувьд авч үзвэл үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого 4,321.3 сая төгрөг буюу 88.3 хувь, бууны албан татварын орлого 75.7 сая буюу 1.6 хувь, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлого 492.1 сая буюу 10.1 хувийг эзэлж байна. Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын өмнөх жилүүдийн өрийг барагдуулах чиглэлээр судалгаа, тооцоо гаргаж мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллаж байгаа тул тухайн орлогыг 12 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн. Галт зэвсгийн албан татварыг цагдаагийн газрын галт зэвсгийн бүртгэлийг үндэслэн 75.7 сая төгрөгөөр төлөвлөсөн.

Бусад татвар, төлбөр хураамж

Төрийн эрх бүхий байгууллагаас “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуульд заасан үйлчилгээ үзүүлсний төлөө иргэн, хуулийн этгээдийн төлж байгаа тэмдэгтийн хураамжийн сүүлийн 5 жилийн гүйцэтгэлд үндэслэн 245.0 сая төгрөгөөр тооцов.

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн хураамж, УТХО-аар хэрэгжиж байгаа авто замын ажилтай холбогдуулан 90.0 сая төгрөгөөр төлөвлөлөө.

2025 оны хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тогтоосон үнэлгээг харгалзан, сумын төвийн өрхийн 90.0 хувиар тооцон 399.0 сая төгрөгөөр төлөвлөв. Цаашид сумын Засаг дарга түүний тамгын газрын холбогдох албан тушаалтнууд “Хог хаягдлын тухай” хуулийн дагуу хогны менежментийг боловсронгуй болгон айл өрх, албан байгууллагуудаас авах хог хаягдлын хураамжийн орлогыг нийгэм эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлэн тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан тогтоож мөрдөх шаардлагатай байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар батлагдсан “Газрын төлбөрийн бааз” болон “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-д тусгасны дагуу газрын төлбөрийн орлогыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай хамтран тооцож 1,608.3 сая төгрөгийг тус орлогын төлөвлөгөөнд тусгалаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдын тушаалын дагуу ойгоос бэлтгэж ашиглах хэрэглээний мод бэлтгэх хуваарийг үндэслэн 2025 оны ойн нөөц ашигласны төлбөр өсөж 492.4 сая төгрөгөөр төлөвлөлөө. Мөн ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2024 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэл гадаадын аялал жуулчлалын урсгал, ангийн зөвшөөрлийн эрхийн бичгийн олголт зэргийг харгалзан 48.0 сая төгрөг болгон төлөвлөлөө. Ус ашигласны төлбөрийн орлогыг 30.5 тэрбум төгрөгөөр төлөвлөж байна.

ГУРАВ. БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДАЛ

Төсвийн зарлагын талаар

Орон нутгийн төсвийн байгууллагуудын төсвийг Монгол улсын 2025 оны төсвийн тухай хууль, Сангийн яамнаас баталсан суурь зардал, сүүлийн жилүүдийн төсвийн гүйцэтгэл, 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд үндэслэн тооцооллыг хийлээ.

2025 оны төсвийн жилд урсгал төсвийн урсгал зарлагатай холбоотой дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

- Иргэдийн орлогыг хамгаалах арга хэмжээг үргэлжлүүлэх хүрээнд төрийн албан хаагчийн цалин, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр болон нийгмийн халамжийн тэтгэврийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ээс 6.0 хувиар нэмэгдүүлэхээр Засгийн газар шийдвэрлэсэн. Үүнтэй холбоотой орон нутгийн төсвийн байгууллагуудын цалингийн тооцооллыг дээрх хувь хэмжээгээр нэмэгдүүлэн тооцоолсон.
- “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2024 оны 86 дугаар дугаар тогтоолоор нутаг дэвсгэрийнхээ нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд суурилуулсан болон аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны теле камерыг нэгдсэн сүлжээнд холбох, хяналт тавих чиг үүрэг бүхий “Теле камерын хяналтын дэд төв”-ийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулахыг даалгасан. Теле камерын хяналтын төвийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэл, үйл ажиллагааны зардалд 198.5 сая төгрөгийг тооцож тусгалаа.
- Орон нутагт төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах зорилгоор 2024 оны 04 дүгээр сараас эхлэн орон нутгийн нэмэгдлийн хувь хэмжээ болон хамрах хүрээг нэмэгдүүлж улс төрийн, төрийн үйлчилгээ, албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг аймгийн төвд 20%, бусад сумдад 40%-иар олгож байна. Засгийн газрын 2019 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар шинэчлэгдэн батлагдсан “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-д дагуу аймгийн төв буюу Булган суманд ажиллаж буй улс төрийн, төрийн захиргаа, төрийн үйлчилгээний 1692 төрийн албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг хөдөөгийн сумдтай ижил түвшинд буюу 40% болгоход (орон нутгийн төсвөөс 20%-иар тооцон олгоно) 7,064.8 сая төгрөгийг тооцсон.
- Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтөд 1,000.2 сая төгрөг, зээлийн хүүгийн төлбөрт 507.3 сая төгрөг, урьд онд төлөх төлбөрийн төлөгдөөгүй үлдэгдэл 820.8 сая төгрөг нийт 2,328.3 сая төгрөгийг төвлөрүүлэхээр 2025 оны суурь орлого, зардалд туссаныг бууруулахгүйгээр тооцож тавьсан.
- Эрчим хүчний зохицуулах хорооны тогтоолын дагуу нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тариф, чадлын тариф

нэмэгдэж байгаа тул гэрэл цахилгааны зардлыг өмнөх жилийн гүйцэтгэл, энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэл, тарифын өөрчлөлт зэргийг харгалзан 30 хувиар нэмэгдүүлэн тооцлоо.

- Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсантай холбоотой орон нутгийн төсвийн байгууллагуудын дотоод албан томилолтын зардлыг суурь түвшингээс 163.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 472.2 сая төгрөгөөр тооцсон.
- Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт, Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын шаардлага хангасан 11 төрийн захиргааны албан хаагчид 99.6 сая төгрөг, Боловсролын тухай хууль, Засгийн газрын 2024 оны 104 дүгээр тогтоолын дагуу 5 төрийн үйлчилгээний албан хаагчдад 41.4 сая төгрөг олгохоор журмын дагуу тооцож тусгалаа.
- Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасан 14 төрийн албан хаагчид нийт 353.9 сая төгрөгийн тэтгэмжийг Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу тооцож тусгасан.
- Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу орон нутгийн суурь зардалд тусгагдсан улсын төсвийн байгууллагуудын байр ашиглалтын зардлын тооцооллыг хийж 14,373.7 сая төгрөгийг тооцож тусгалаа. Булган аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тогтоолоор дулаан эрчим хүчний тарифт өөрчлөлт орсон 9 сумын тарифын өөрчлөлтийн зөрүү, эрчим хүчний чадлын болон цахилгааны тарифын өөрчлөлтийг дээрх дүнд тусгасан болно.
- Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын дагуу “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заасны дагуу сумын төсөвт төвлөрүүлэх орлогын хэсгээр санхүүжих байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 707.0 сая төгрөгийг сумын суурь зардалд тусгасан. Сумдад 2.3-141.2 сая төгрөг хуваарилагдаж байна.
- Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын хуралдаанаар батлуулахаар ажиллаж байна. Мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд 1,000.0 сая төгрөгийг тусгасан.
- Аймаг, сумын Засаг даргын нөөц хөрөнгийг урьд оны гүйцэтгэл, өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал зэргийг харгалзан 1,225.0 сая төгрөг буюу аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг 800.0 сая, сумын Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг тус бүр 25.0 сая төгрөг байхаар тооцож тусгасан.

2025 оны төсвийн тооцоонг хүснэгтлэн харуулбал:

Хүснэгт №02. Аймгийн шууд харьяа байгууллагуудын төсвийн тооцоо

(мянган төгрөг)

Д/д	Байгууллага, арга хэмжээний нэр	2025 оны төсвийн төсөл
1	Аймгийн ИТХ	1,456,611.6
2	Аймгийн ЗДТГ	4,921,029.5
3	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	800,000.0
4	Санхүүгийн хяналт, аудитын алба	509,923.4
5	Орон нутгийн өмчийн газар	427,354.3
6	Худалдан авах ажиллагааны газар	317,774.6
7	Байгаль орчин аялал жуулчлалын газар	2,010,239.8
8	Хүүхдийн сувилал	644,525.7
9	Хотын нийтийн хүн тээвэр	18,000.0
10	Халамжийн сан	158,050.0
11	Гамшгаас хамгаалах сан	100,000.0
12	Цэргийн дүйцүүлэх алба	100,000.0
13	Цэвэрлэх байгууламж	450,000.0
14	Мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардал	1,000,000.0
15	Дамжуулан олгосон зээлийн төлбөр, хүүгийн төлбөр	2,328,333.3
16	Ахмадын хороо	189,276.0
17	Мал эмнэлгийн үйлчилгээ	1,168,721.9
18	Улсын төсвийн байгууллагын байр ашиглалтын зардал	2,861,417.5
19	Аймгийн төв буюу Булган сумын улс төрийн, төрийн захиргаа, төрийн үйлчилгээний албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдэл	4,864,278.0
	Нийт дүн	24,325,535.6

Суманд олгох санхүүгийн дэмжлэг

Суурь зардалд орон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, ойн анги, тохижилт үйлчилгээний ангийн зардал, байр ашиглалт болон үйлчилгээний зардал, байгаль нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг тооцоолсон.

Суманд олгох санхүүгийн дэмжлэгийг суурь зардал, суурь орлогын зөрүүгээр тооцоолсон ба 14 сум, 1 тосгонд 15,338.2 сая төгрөгийг олгож, 2 сумаас 2,227.3 сая төгрөгийг төвлөрүүлж авахаар байна.

Хүснэгт №03. 2025 оны суманд олгох санхүүгийн дэмжлэг

(мянган төгрөг)

№	Сумын нэр	Суурь орлого	Суурь зарлага	Санхүүгийн дэмжлэг
1	Баян-Агт	581,830.9	1,992,985.2	1,411,154.3
2	Баяннуур	547,415.2	1,503,288.5	955,873.3
3	Бугат	618,115.5	1,669,207.9	1,051,092.4
4	Булган	10,131,947.0	6,954,030.0	
5	Бүрэгхангай	1,893,037.1	1,930,930.8	37,893.7
6	Гурванбулаг	652,146.1	1,969,793.7	1,317,647.6
7	Дашинчилэн	710,860.6	2,103,633.4	1,392,772.8

8	Могод	632,617.5	1,742,069.2	1,109,451.7
9	Орхон	838,693.9	1,803,412.8	964,718.9
10	Рашаант	1,487,782.9	1,957,871.4	470,088.5
11	Сайхан	605,134.4	1,758,610.6	1,153,476.2
12	Сэлэнгэ	793,991.6	2,155,295.9	1,361,304.3
13	Тэшиг	1,274,644.8	2,054,775.8	780,131.0
14	Хангал	4,278,029.3	1,767,109.4	
15	Хишиг-Өндөр	696,669.2	2,068,548.4	1,371,879.2
16	Хутаг-Өндөр	1,494,241.1	2,398,895.4	904,654.3
17	Хялганат	968,052.7	2,024,106.9	1,056,054.2
	Сумын дүн	28,205,209.8	37,854,565.1	15,338,192.2

Булган, Хангал сумын төсвийн үндсэн тэнцлийн ашгаас Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2 хэсэгт заасны дагуу аймгийн төсөвт төвлүүлэх орлогыг тооцоолсон.

Хүснэгт №04. 2025 онд сумаас аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ
(мянган төгрөг)

№	Сумын нэр	Үндсэн тэнцэл	Суманд үлдэх	Аймагт төвлөрүүлэх
1	Булган	3,177,917.00	2,224,541.90	953,375.10
2	Хангал	2,510,919.90	1,236,976.50	1,273,943.40
	Дүн	5,688,836.90	3,461,518.40	2,227,318.50

Орон нутгийн хөгжлийн сан

Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуулиар орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 15,258.1 сая төгрөгөөр батлагдсан.

Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал”-ын тооцоолол хийхэд суманд орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээр нийт 9,953.0 сая төгрөгийг олгож, аймгийн орон нутгийн хөгжлийн санд 5,305.1 сая төгрөг хуваарилагдаж байна.

Хүснэгт №05. 2025 оны сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн тооцоолол

(мянган төгрөг)

№	Сум	Итгэлцүүрээр хуваарилагдах нийт дүн	Өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ /ЖГҮ/	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	Сумдын ОНХС-д хуваарилагдах суурь дүн
1	Баян-Агт	314,676.8	61,925.3	-	-	376,602.0
2	Баяннуур	233,764.4	45,622.2	2,606.0	18,604.0	300,596.6
3	Бугат	288,270.5	84,109.9	19,022.0	1,525.0	392,927.4
4	Булган	549,117.0	162,664.1	-	-	711,781.1
5	Бүрэгхангай	1,020,454.2	200,129.6	17,323.0	127,718.0	1,365,624.8
6	Гурванбулаг	312,740.0	91,972.7	1,164.0	1,327.0	407,203.7
7	Дашинчилэн	611,350.8	120,850.8	-	53,675.0	785,876.6
8	Могод	270,737.8	53,153.9	-	-	323,891.7
9	Орхон	1,436,515.7	-	12,359.0	162,904.0	1,611,778.7
10	Рашаант	192,150.2	56,845.2	-	-	248,995.4
11	Сайхан	387,618.5	115,287.1	13,656.0	380.0	516,941.6
12	Сэлэнгэ	545,870.6	107,515.0	7,607.0	23,074.0	684,066.6
13	Тэшиг	724,080.3	142,077.8	-	24,114.0	890,272.1
14	Хангал	281,540.1	56,019.0	1,318.0	-	338,877.1
15	Хишиг-Өндөр	262,170.8	52,473.6	987.0	98.0	315,729.5
16	Хутаг-Өндөр	526,601.5	155,199.0	35.0	-	681,835.5
Нийт		7,957,659.2	1,505,845.1	76,077.0	413,419.0	9,953,000.3

2025 ОНЫ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, САНХҮҮЖИЛТИЙН ТООЦОО

2024-11-15

СУМ/ БАЙГУУЛАЛГЫН НЭР	СУУРЬ ЗАРДАЛ								СУУРЬ ОРЛОГО	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ	
	Сумын ИТХ	Сумын ЗДТГ	Багийн засаг дарга	ЗДНХөрсөг	Тогтмол	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх	Хот тохижуулах газар	Сум дундын ойн анги			ДҮН
Баян-Агт	201,234.7	861,119.2	232,154.1	25,000.0	623,832.6	49,644.6			1,992,985.2	581,830.9	1,411,154.3
Баяннуур	197,196.3	837,132.0	120,283.3	25,000.0	321,366.0	2,310.9			1,503,288.5	547,415.2	955,873.3
Бугат	197,920.4	905,585.1	119,583.3	25,000.0	364,581.8	56,537.3			1,669,207.9	618,115.5	1,051,092.4
Булган	301,049.2	1,362,613.7	653,730.8	25,000.0	2,479,495.2	5,924.8	1,944,473.5	181,742.8	6,954,030.0	10,131,947.0	-3,177,917.0
Бүрэгхангай	198,946.5	906,159.7	157,309.4	25,000.0	502,352.3	141,163.0			1,930,930.8	1,893,037.1	37,893.7
Гурванбулаг	217,078.7	924,198.0	232,154.1	25,000.0	567,966.7	3,396.1			1,969,793.7	652,146.1	1,317,647.6
Дашинчилэн	190,129.9	931,215.2	157,309.4	25,000.0	792,932.0	7,046.8			2,103,633.4	710,860.6	1,392,772.8
Могод	206,184.4	910,162.5	194,878.0	25,000.0	394,477.3	11,367.0			1,742,069.2	632,617.5	1,109,451.7
Орхон	200,762.7	987,295.5	194,878.0	25,000.0	311,182.7	84,293.9			1,803,412.8	838,693.9	964,718.9
Рашаант	195,603.5	959,354.2	158,309.4	25,000.0	606,553.9	13,050.3			1,957,871.4	1,487,782.9	470,088.5
Сайхан	214,660.8	820,617.5	232,154.1	25,000.0	457,381.2	8,797.0			1,758,610.6	605,134.4	1,153,476.2
Сэлэнгэ	203,178.0	952,822.6	194,878.0	25,000.0	724,099.4	55,317.8			2,155,295.9	793,991.6	1,361,304.3
Төшиг	212,828.9	835,301.6	195,368.0	25,000.0	671,641.4	114,635.8			2,054,775.8	1,274,644.8	780,131.0
Хангал	193,117.0	1,024,278.1	119,223.3	25,000.0	359,090.4	46,400.6			1,767,109.4	4,278,029.3	-2,510,919.9
Хишиг-Өндөр	211,100.3	927,744.0	194,878.0	25,000.0	694,280.3	15,545.8			2,068,548.4	696,669.2	1,371,879.2
Хутаг-Өндөр	202,430.8	893,211.6	132,890.5	25,000.0	845,311.8	91,579.4		208,471.4	2,398,895.4	1,494,241.1	904,654.3
Хялганат	0.0	986,632.8	0.0	25,000.0	795,789.5	0.0		216,684.6	2,024,106.9	968,052.7	1,056,054.2
Сумын төсвийн дүн	3,343,422.1	16,025,443.3	3,289,981.7	425,000.0	11,512,334.6	707,011.1	1,944,473.5	606,898.8	37,854,565.1	28,205,209.8	9,649,355.3
Аймгийн ИТХ									1,276,611.6		1,276,611.6
Аймгийн ЗДТГ									4,921,029.5	10,000.0	4,911,029.5
Санхүүгийн хяналт,									509,923.4		509,923.4
ГХУС									180,000.0		180,000.0
Аймгийн Ахмадын хороо									189,276.0		189,276.0
ЗДНөөц									800,000.0		800,000.0
Хотын нийтийн хүн тээвэр									18,000.0		18,000.0
Орон нутгийн Өмчийн									427,354.3		427,354.3
Байгаль хамгаалах сан									10,954,468.8		10,954,468.8
Тариф өөрчлөлт									5,950,002.5		5,950,002.5
Замын сан									1,574,900.2		1,574,900.2
Бай.Орч.Газар									2,010,239.8		2,010,239.8
ХААГазар									317,774.6	4,000.0	313,774.6
Теле хяналтын дэд төв									212,661.6		212,661.6
Сувилалын ясли									644,525.7		644,525.7
Цэвэрлэх байгууламж									450,000.0		450,000.0
Орон нутгийн ХО									2,699,582.9		2,699,582.9
Халамжийн сан									158,050.0		158,050.0
Үндсэн тэнцэл ашиг									3,461,518.4		3,461,518.4
Хуулиар олгогдсон чиг									150,000.0		150,000.0
Гамшгаас хамгаалах сан									100,000.0		100,000.0
Цэргийн дүйцүүлэх алба									100,000.0	100,000.0	0.0
Мөрийн хөтөлбөр									1,000,000.0		1,000,000.0
Мал эмнэлгийн вакцины үнэ									1,168,721.9		1,168,721.9
УТБ цалин									4,864,278.0		4,864,278.0
Дамжуулан зээл									1,821,021.4	1,000,171.4	820,850.0
Зээлийн хүүгийн төлбөр									507,311.9		507,311.9
УТБ Тогтмол зардал									2,861,417.5	30,000.0	2,831,417.5
ХО: Их засвар									380,700.0		380,700.0
Аймгийн төсвийн дүн									49,709,370.1	1,144,171.4	48,565,198.7
Аймгийн төсвийн орлого										34,097,254.0	
Санхүүгийн дэмжлэг										24,117,300.0	
НИЙТ ДҮН									87,563,935.2	87,563,935.2	58,214,554.0

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ОНХС-ААС СУМ, ДҮҮРГИЙН ОНХС-Д ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙН СУУРЬ ТООЦООЛОЛ

/Батлагдсан аргачлалаар/

Аймагт хуваарилагдсан нийт дүн		15,258,106.4
1	Өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагаа	1,505,845.1
2	АМХТЗТ	76,077.0
3	АМАТЗТ	413,419.0
Итгэлцүүрээр хуваарилагдах дүн		13,262,765.3
Итгэлцүүрээр хуваарилагдах суурь дүн /50%/		60% 7,957,659.2

Итгэлцүүр		
Хүн амын тоо	33%	2,626,027.5
Нутаг дэвсгэр	34%	2,705,604.1
Ашигт малтмал, газрын тосны аш	33%	2,626,027.5
100%		

№	Код	Аймаг	Сум	Нутаг дэвсгэрийн хэмжээ, мян.км2	Хүн амын тоо /мян.хүн/	Аймаг хүртэлх зай /км/	Ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбай	Ашигт малтмал болон газрын тосны индекс	Хүн амын тооноос хамааруулан олгох дүн	Нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамааруулан олгох дүн	Ашигт малтмал, газрын тосны ашиглалтын талбайн хэмжээнээс хамааруулан олгох дүн	Итгэлцүүрээр хуваарилагдах нийт дүн	Өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ /ЖГҮ/	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	Сумдын ОНХС-д хуваарилагдах суурь дүн
1	26304	Булган	Баян-Агт сум	3.0797	3.3	150	-	-	143,691.3	170,985.4	-	314,676.8	61,925.3	-	-	376,602.0
2	26307	Булган	Баяннуур сум	0.9601	1.9	181	1,545.5	0.0	81,904.5	53,303.2	98,556.7	233,764.4	45,622.2	2,606.0	18,604.0	300,596.6
3	26310	Булган	Бутаг сум	3.0045	2.2	52	420.7	0.0	94,635.5	166,808.1	26,826.8	288,270.5	84,109.9	19,022.0	1,525.0	392,927.4
4	26301	Булган	Булган сум	0.1000	12.5	0	-	-	543,567.8	5,549.2	-	549,117.0	162,664.1	-	-	711,781.1
5	26313	Булган	Бүрэгхангай сум	3.4979	3.0	80	10,946.7	0.3	128,179.4	194,205.1	698,069.7	1,020,454.2	200,129.6	17,323.0	127,718.0	1,365,624.8
6	26316	Булган	Гурванбулаг сум	2.6861	3.2	140	366.2	0.0	140,258.7	149,129.9	23,351.3	312,740.0	91,972.7	1,164.0	1,327.0	407,203.7
7	26319	Булган	Дашинчилэн сум	2.3190	2.9	150	5,601.4	0.1	125,398.6	128,749.0	357,203.2	611,350.8	120,850.8	-	53,675.0	785,876.6
8	26322	Булган	Могод сум	2.8205	2.6	131	-	-	114,144.9	156,593.0	-	270,737.8	53,153.9	-	-	323,891.7
9	26325	Булган	Орхон сум	4.2148	3.3	22	16,598.9	0.4	143,995.5	234,005.3	1,058,514.9	1,436,515.7	-	12,359.0	162,904.0	1,611,778.7
10	26328	Булган	Рашаант сум	1.0121	3.1	220	-	-	135,957.1	56,193.1	-	192,150.2	56,845.2	-	-	248,995.4
11	26331	Булган	Сайхан сум	2.7728	3.4	101	1,334.1	0.0	148,601.3	153,944.1	85,073.1	387,618.5	115,287.1	13,656.0	380.0	516,941.6
12	26334	Булган	Сэлэнгэ сум	4.8295	3.3	135	2,121.7	0.1	142,431.3	268,135.7	135,303.6	545,870.6	107,515.0	7,607.0	23,074.0	684,066.6
13	26337	Булган	Тэшиг сум	7.7190	3.5	246	2,217.4	0.1	154,119.5	428,560.1	141,400.6	724,080.3	142,077.8	-	24,114.0	890,272.1
14	26340	Булган	Хангал сум	1.6556	4.4	113	-	-	189,618.7	91,921.4	-	281,540.1	56,019.0	1,318.0	-	338,877.1
15	26343	Булган	Хишиг-Өндөр сум	2.4551	2.9	68	27.1	0.0	124,138.5	136,304.8	1,727.5	262,170.8	52,473.6	987.0	98.0	315,729.5
16	26346	Булган	Хутаг-Өндөр сум	5.6055	5.0	143	-	-	215,384.9	311,216.6	-	526,601.5	155,199.0	35.0	-	681,835.5
Нийт				48,7319	60.4		41,179.6	1.0	2,626,027.5	2,705,604.1	2,626,027.5	7,957,659.2	1,505,845.1	76,077.0	413,419.0	9,953,000.3

2025 онд Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд хуваарлагдах дүн

№	Сумын нэр	ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр		Ус ашигласны төлбөр		Газрын төлбөр		Ан амьтан барих зөвшөөрлийн хураамж		Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр		Сумын дэмжлэгт тооцогдох зардал
		Орлого	Зардал	Орлого	Зардал	Орлого	Зардал	Орлого	Зардал	Орлого	Зардал	
1	Баян-Агт	48,350.8	41,098.2	14,000.0	4,900.0	15,079.6	2,261.9	2,769.0	1,384.5		-	49,644.6
2	Баяннуур		-	5,000.0	1,750.0	3,739.6	560.9		-		-	2,310.9
3	Бугат	59,670.2	50,719.7	1,000.0	350.0	28,968.2	4,345.2	2,156.0	1,078.0	296.0	44.4	56,537.3
4	Булган		-	4,000.0	1,400.0	30,165.0	4,524.8	-	-		-	5,924.8
5	Бүрэгхангай	11,787.3	10,019.2	4,000.0	1,400.0	861,805.2	129,270.8	946.0	473.0		-	141,163.0
6	Гурванбулаг		-	7,000.0	2,450.0	6,307.4	946.1		-		-	3,396.1
7	Дашинчилэн		-	500.0	175.0	45,812.1	6,871.8		-		-	7,046.8
8	Могод	5,005.6	4,254.8	5,500.0	1,925.0	14,248.1	2,137.2	6,100.0	3,050.0		-	11,367.0
9	Орхон	47,890.5	40,706.9	2,000.0	700.0	282,256.4	42,338.5	1,097.0	548.5		-	84,293.9
10	Рашаант		-	13,000.0	4,550.0	56,668.9	8,500.3		-		-	13,050.3
11	Сайхан	8,248.0	7,010.8	500.0	175.0	10,741.2	1,611.2		-		-	8,797.0
12	Сэлэнгэ	53,202.8	45,222.4	1,000.0	350.0	41,117.1	6,167.6	7,067.0	3,533.5	296.0	44.4	55,317.8
13	Тэшиг	106,953.6	90,910.6	500.0	175.0	84,331.1	12,649.7	21,707.0	10,853.5	314.0	47.1	114,635.8
14	Хангал	42,093.9	35,779.8	1,200.0	420.0	60,847.4	9,127.1	2,058.0	1,029.0	298.0	44.7	46,400.6
15	Хишиг-Өндөр	13,078.9	11,117.1	6,000.0	2,100.0	15,524.9	2,328.7		-		-	15,545.8
16	Хутаг-Өндөр	96,111.0	81,694.4	500.0	175.0	50,704.0	7,605.6	4,120.0	2,060.0	296.0	44.4	91,579.4
17	Хялганат		-	-	-		-		-		-	-
	Сумын дүн	492,392.6	418,533.7	65,700.0	22,995.0	1,608,316.2	241,247.4	48,020.0	24,010.0	1,500.0	225.0	707,011.1

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дахь
удаагийн сонгуулийн Хуралдааны ... дүгээр
тогтоолын ... дүгээр хавсралт

**2025 оны төсвийн жилд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх
хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалт**

/мянган төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр байршил, хүчин чадал	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжүүлэх дүн
1. Шилжих хөрөнгө оруулалт				530,000.0	530,000.0
1.1	Сумын төвийн хатуу хучилттай авто зам барих ажлын үргэлжлэл (Тэшиг сум)	2024	2025	300,000.0	300,000.0
1.2	Аймгийн Засаг даргын тамгын газрын лифтны тоноглол, засвар	2024	2025	70,000.0	70,000.0
1.3	Лед дэлгэц шинээр худалдаж авах (Баян-агт сум)	2024	2025	40,000.0	40,000.0
1.4	Усан шүүлтүүртэй халаалтын тогоо шинэчлэх 1,8мвт (Хутаг-Өндөр сум)	2024	2025	120,000.0	120,000.0
2. Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ				3,816,120.0	1,448,582.9
2.1	Булган сумын Булган багийн Залуус хэсгийн 3,2 км явган зам гэрэлтүүлэг бүхий хатуу хучилттай авто зам (Булган, Булган сум)	2025	2025	3,741,800.0	1,374,262.9
2.2	Хүүхдийн цэцэрлэгийн 75 хүүхдийн өргөтгөлийн барилгын нэмэлт ажил (Хангал сум)	2025	2025	74,320.00	74,320.00
3.Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл				721,000.0	721,000.0
3.1	Хяналтын камерийн хүчин чадлыг нэмэгдүүлэх (Булган сум)	2025	2025	400,000.0	400,000.0
3.2	Эрүүл мэндийн төвүүдэд нярайн шарлагын аппарат авах (18ш)	2025	2025	126,000.0	126,000.0
3.3	Татварын газрын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл	2025	2025	25,000.0	25,000.0
3.4	Тусгай зориулалтын ариутгалын тоноглогдсон автомашин	2025	2025	80,000.0	80,000.0
3.5	Мал эмнэлгийн газрын зөөврийн рентген оношлогооны аппарат авах	2025	2025	90,000.0	90,000.0
НИЙТ				5,067,120.0	2,699,582.9

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
дахь удаагийн сонгуулийн Хуралдааны ...
дүгээр тогтоолын ... дүгээр хавсралт

**2025 оны төсвийн жилд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх
их засварын ажлын жагсаалт**

(мян.төг)

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
1. Шилжих их засвар:				344,700.0	344,700.0
1.1	Гурванбулаг сумын ЗДТГ-ын барилгын засвар	2024	2025	120,000.0	120,000.0
1.2	Ахуйн үйлчилгээний барилгын гадна бохирын системийн угсралтын ажил (Гурванбулаг сум)	2024	2025	126,000.0	126,000.0
1.3	ЕБСургуулийн сантехникийн засвар (Дашинчилэн сум)	2024	2025	30,000.0	30,000.0
1.4	МСҮТ-ийн барилгын засварын орон нутгийн оролцооны хөрөнгө (Булган сум)	2024	2025	68,700.0	68,700.0
2. Шинээр хэрэгжих их засвар				36,000.0	36,000.0
2.1	Төрийн албан хаагчийн орон сууцны барилгын цахилгааны засварын нэмэлт ажил (Баяннуур сум)	2025	2025	36,000.0	36,000.0
Нийт дүн				380,700.0	380,700.0

**2025 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх
төсөл арга хэмжээний жагсаалт**

/мянган төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр байршил, хүчин чадал	Хамрах салбар	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжүүлэх дүн
1. Шилжих төсөл, арга хэмжээ					480,000.0	480,000.0
1.1	Нэгдсэн эмнэлгийн лифт, хүлээн авахын хэсгийн засвар, тоноглол (Булган сум)	Эрүүл мэндийн салбар	2024	2025	400,000.0	400,000.0
1.2	Сумын эрүүл мэндийн төвийн барилгын засвар (Могод сум)	Эрүүл мэндийн салбар	2024	2025	80,000.0	80,000.0
2. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ					6,789,801.8	5,305,103.4
2.1	Аймгийн төвийн 9, 36, 11, 211, 209, Биеийн тамир спортын газар, 19, 20-р байрны гадна цэвэр, дулааны шугамын өргөтгөл, хэрэгцээний халуун усны 5 хос шугам татах ажил (Булган сум)	Дэд бүтэц	2025	2025	950,000.00	950,000.00
2.2	Орон нутагт ирж ажиллах боловсон хүчинд амьдрах, төрийн албан хаагчдын 4-н айлын орон сууц барих ажил (Орхон сум)	Нийгмийн салбар	2025	2025	380,000.00	380,000.00
2.3	Орон нутагт ирж ажиллах боловсон хүчинд амьдрах, төрийн албан хаагчдын 4-н айлын орон сууц барих ажил (Хишиг-Өндөр сум)	Нийгмийн салбар	2025	2025	380,000.00	380,000.00
2.4	Ус хангамж, ариутгал татуургын төвлөрсөн шугам сүлжээний ажлыг эхлүүлэх (Могод сум)	Дэд бүтэц	2025	2026	3,157,163.30	1,672,464.90
2.5	Хялганат тосгоны Шар тал хэсгийн шинэ суурьшлын бүсийн 10/0,4 кВт-ын ЦДАШ, 250 кВт-ын дэд станцын цахилгааны ажил (Хялганат тосгон)	Дэд бүтэц	2025	2025	90,000.00	90,000.00
2.6	Сумын төвд гэрэлтүүлгийн өргөтгөл, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажил (Баян-Агт сум)	Дэд бүтэц	2025	2025	80,000.00	80,000.00
2.7	Хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулах	Дэд бүтэц	2025	2025	800,000.00	800,000.00
2.8	Аймгийн баяр наадмын зардал	Нийгмийн салбар	2025	2025	120,000.00	120,000.00
2.9	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны их засвар (Тэшиг сум)	Дэд бүтэц	2025	2025	832,638.50	832,638.50
НИЙТ					7,269,801.8	5,785,103.4

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
дахь удаагийн сонгуулийн Хуралдааны ...
дүгээр тогтоолын ... дүгээр хавсралт

**2024 оны төсвийн жилд автозамын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх
төсөл, арга хэмжээний жагсаалт**

(мянган
төгрөг)

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
1. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ				1,574,900.2	1,574,900.2
1.1	Ургац тээврийн авто замын засвар	2025	2025	100,000.0	100,000.0
1.2	Орон нутгийн чанартай авто замын засвар, арчлалт	2025	2025	250,000.0	250,000.0
1.3	Байгалийн гамшгийн үеийн авто зам, замын байгууламжийн засвар	2025	2025	60,000.0	60,000.0
1.4	Сумын төвийн зам засвар (Булган сум)	2025	2025	300,000.0	300,000.0
1.5	Үерийн байгууламж цэвэрлэж, засварлах (Булган сум)	2025	2025	80,000.0	80,000.0
1.6	Хийгдсэн зураг төсвийн төсөв шинэчлэх (Булган сумын 4,6-р багийн төсөв шинэчлэх)	2025	2025	10,000.0	10,000.0
1.7	Зам, тээврийн хяналтын төвийн тог цахилгааны зардал	2025	2025	15,000.0	15,000.0
1.8	Зоон давааны цагдаагийн пост авто пүү янзалж, талбай засах	2025	2025	50,000.0	50,000.0
1.9	Хөндлөнгийн хяналт тавих (Авто замын хяналтын улсын байцаагч)	2025	2025	5,000.0	5,000.0
1.11	Аймгийн төвд нийтийн 2000м ² нийтийн зогсоол хийх	2025	2025	284,655.0	284,655.0
1.12	Булган аймгийн ЗДТГ-ын авто зогсоолын өргөтгөл, шинэчлэл	2025	2025	420,245.2	420,245.2
1.13					
Нийт дүн				1,574,900.2	1,574,900.2

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт

(мян. төг)

д/д	Хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, тоо хэмжээ	хэрэгжүүлэх хугацаа	төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
Шилжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ				
1	Тарвага сэргээн нутагшуулах (Дашинчилэн сум)	2024-2025	18,000.0	9,000.0
2	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд цөлжилт элсний нүүдлээс хамгаалах зурвасын ажил (12 га, Рашаант 3га, Баяннуур 3 га, Гурванбулаг 3 га, Дашинчилэн 3га)	2024-2025	180,000.0	90,000.0
3	Цэвэр усны даралтат цамхаг шинээр барих 1-р шатны ажил (Хангал сум)	2023-2025	228,850.0	128,435.6
4	Цэвэр усны даралтат цамхаг 2-р шатны ажил (Хангал сум)	2023-2025	234,000.0	121,101.2
5	Цэвэр усны даралтат цамхаг барих 3-р шатны ажил (Хангал сум)	2024-2025	300,000.0	300,000.0
6	Булган сумын нефть, нефтийн бүтээгдэхүүнээр бохирлогдсон газрыг эрүүлжүүлэх, нөхөх сэргээх	2024-2025	50,000.0	50,000.0
Дүн			1,010,850.0	698,536.8
1. Усны нөөц хамгаалах, усан хангамжийг сайжруулах чиглэлээр				
8	Гурванбулаг сумын Зүүн уртын баруун салаанд хөв цөөрөм байгуулах.	2025-2025	284,129.2	284,129.2
9	Рашаант сумын Савангийн голын хар үзүүрт хөв цөөрөм байгуулах.	2025-2025	231,900.7	231,900.7
10	Усны тоо бүртгэлийн ажил зохион байгуулах.	2025-2025	9,486.6	9,486.6
Дүн			525,516.50	525,516.50
2. Ой, цөлжилтийн талаар:				
11	Аймгийн хэмжээнд 2025-2028 оны "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ойжуулалт, ойн зурвас байгуулах ажлын зураг төсөл боловсруулах ажлын эхний үе 62.5 га талбайд хийх	2025-2025	125,000.0	125,000.0
12	Сум дундын ойн ангиуд үр түүх байнгын болон түр талбайг арчлах (30 га)	2025-2025	32,361.0	32,361.0
13	Ойн ангиудын тоног төхөөрөмж, арчилгаа, хамгаалалтын ажлын зардал	2025-2025	100,000.0	100,000.0
14	Ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар 2 худаг шинээр гаргах (Могод, Сайхан сум)	2025-2025	30,000.0	30,000.0
15	Доройтсон бэлчээрийн газрыг нөхөн сэргээх, ойн зурвасын усалгааны зориулалтаар шинээр худаг гаргах (10 ш)	2025-2025	270,000.0	270,000.0
16	Ойн хортны судалгааны ажил (ой бүхий сумдад 400.000 га талбайд)	2025-2025	125,600.0	125,600.0
17	Ойн хортны тэмцлийн ажлыг үүргийн шүршигч багаж ашиглан микробиологийн аргаар тэмцэх (Орхон, Бугат, Сайхан, Хутаг-Өндөр, Баян-Агт, Хангал сум - 15000 га)	2025-2025	1,920,000.0	1,920,000.0
18	Ойн таваарлаг чанарыг нэмэгдүүлэх зорилгоор насны I, II ангийн ойд арчилгааны огтлолт хийх (70 га, Бугат, Орхон, Хангал сумдад)	2025-2025	165,690.0	165,690.0

19	Могод сум "Цагаан овоо"-г ойжуулах төсөл (151 га талбайг)	2025-2025	110,525.0	110,525.0
20	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд элсний нүүдлээс хамгаалах зурвасын ажлыг байгуулах (Орхон, Сэлэнгэ сум 6 га)	2025-2025	882,144.0	882,144.0
21	Хутаг-Өндөр сумын Гуртын гүүрний элсний нүүдлийг багасгах ногоон байгууламж барих	2025-2025	100,000.0	100,000.0
22	Булган сумын 6-р баг Залуус хэсгийн 15, 16, 17-р гудамжны дулааны шугам өргөтгөл	2025-2025	797,531.5	797,531.5
23	Хялганат тосгоны дан байрны дулаан, цэвэр усны шугамын өргөтгөлийн 2-р шатны ажил	2025-2025	335,000.0	335,000.0
24	Булган сумын 3 дугаар Ус дулаан дамжуулах төвөөс 7 дугаар цэцэрлэг хүртэлх ДХ143-ДХ129-р худаг чиглэлийн гадна дулаан, цэвэр, хэрэгцээний халуун усны шугамын өргөтгөл, шинэчлэл	2025-2025	750,000.0	750,000.0
	Дүн		5,743,851.50	5,743,851.50
3. Газар, газрын хэвлийг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах хог хаягдлыг багасгах талаар				
25	Уул уурхайн олборлолт болон авто замын бүтээн байгуулалтын улмаас эвдэрсэн газрын судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж нөхөн сэргээлтийн зардлыг тогтоолгох	2025-2025	100,000.0	100,000.0
26	Их булгийн рашаан, Цагаан гол, Хануй, Хунтын рашаан сувиллын газруудын нэгдсэн ариун цэврийн байгууламжийн зураг төсөв хийлгэх	2025-2025	50,000.0	50,000.0
27	Булган аймагт баригдах нийтийн ариун цэврийн байгууламжийн жишиг зураг төсөв хийлгэх	2025-2025	30,000.0	30,000.0
28	Хануйн рашааны онцгой хамгаалалтын бүст (Хүрмэн доор) зөөврийн био 00 авч суурилуулах	2025-2025	25,000.0	25,000.0
29	Хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах "Цэвэр орчин" аян зохион байгуулах	2025-2025	50,000.0	50,000.0
30	Сумын төвийн орон сууцыг хог ангилах ялгах хогийн савтай болгох (Булган сум 30ш)	2025-2025	75,000.0	75,000.0
31	Булган суманд байгуулах дахивар нөөц авах цэгийн зураг төсөл боловсруулах	2025-2025	20,000.0	20,000.0
32	Булган суманд хатуу хуванцар бутлагч авч суурилуулах	2025-2025	25,000.0	25,000.0
33	Химийн бодис, аюултай хог хаягдал үүсгэгчийн тооллого, зохион байгуулах	2025-2025	20,000.0	20,000.0
34	Сумдыг ээлж дараатай хатуу хог хаягдлыг технологийн дагуу өндөр даралтаар шатаах зуухаар хангах (Булган сум)	2025-2025	166,000.0	166,000.0
35	Хутаг-Өндөр, Сайхан, Хангал сумдыг бохир соруулах техникээр хангах	2025-2025	180,000.00	180,000.00
36	Мал эмнэлгийн лабораторын пестицидээр бохирдсон талбайг цэвэршүүлэх	2025-2025	300,000.0	300,000.0
37	Рашаант, Гурванбулаг, Дашинчилэн сумдыг хог дарж булах техникээр хангах	2025-2025	240,000.0	240,000.0
	Дүн		1,281,000.0	1,281,000.0
4. Биологийн төрөл зүйлийг хамгаалах				
38	Нэн ховор, ховор амьтдын тархац нутагт биотехникийн арга хэмжээ авах	2025-2025	20,000.0	20,000.0
	Дүн		20,000.00	20,000.00
5. Ногоон хөгжлийн бодлого, аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээнүүд				
39	Байгаль орчинд ээлтэй дулааны үйлдвэрлэлийг бий болгох, хөгжүүлэх	2025-2025	2,500,000.0	2,500,000.0
40	Тусгай хамгаалалтай бүсэд байгаа түүх, соёлын дурсгалыг хамгаалах, хөгжүүлэх, сурталчилан таниулах	2025-2025	50,000.0	50,000.0

	Дүн		2,550,000.00	2,550,000.00
	6. Бусад			
41	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдэд иргэдэд зориулсан сургалт сурталчилгаа, сумдын БОХУБайцаагч, Байгаль хамгаалагч нарт сургалт зохион байгуулах.	2025-2025	40,000.0	40,000.0
42	Хүүхэд залуучуудад экологийн боловсрол олгох ажлыг зохион байгуулах (1.Рашаант, Дашинчилэн, Гурванбулаг, Баяннуур 2.Бүрэгхангай, Хишиг-Өндөр, Могод, Орхон)	2025-2025	15,000.0	15,000.0
43	Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааны зардал	2025-2025	15,564.0	15,564.0
44	Хог ангилан ялгах шторк хийлгэж, орон нутгийн телевиз, олон нийтийн сүлжээгээр цацах	2025-2025	20,000.0	20,000.0
45	Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах хяналт шалгалт хийх (хууль бус мод бэлтгэл, ой, хээрийн түймэр, ан агнуур, хог хаягдал, орчны бохирдол, ус, рашаан нөөц ашиглах, ашигт малтмал, хяналт үнэлгээ хийх)	2025-2025	20,000.0	20,000.0
46	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх тарьц, суулгацын үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	2025-2025	10,000.0	10,000.0
47	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны "Журам батлах тухай" А/738 дугаар тушаалаар батлагдсан албаны хувцсаар хангах (Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч 1, улсын байцаагч 2)	2025-2025	15,000.0	15,000.0
	Дүн		135,564.0	135,564.0
	Нийт дүн		11,266,782.0	10,954,468.8